

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**



**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУНД ХУГАЦААНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

/2017-2020 он/

**Улаанбаатар хот
2017 он**

Агуулга

1. УДИРТГАЛ	2
2. ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ	3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулсан арга зүй:

1.1. Үндэслэл	4
1.2. Эрх зүйн орчин	4
1.3. Арга зүй	4-6
1.4. Орчны шинжилгээ	6-7

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн үндсэн чиглэл:

2.1. Алсын хараа	8
2.2. Эрхэм зорилго	8
2.3. Үнэт зүйлс	8
2.4. Эрхэмлэх зарчим	8-9
2.5. Үйл ажиллагааны хамрах хүрээ	9
2.5.1. Үйл ажиллагааны стратегийн зорилго	9
2.5.2. Үйл ажиллагааны стратегийн зорилт	9
2.6. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн	9-12
2.7. Хэрэгжүүлэх хугацаа	12
2.8. Санхүүжилт	12

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт:

3.1. 2017-2020 онд эн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл /нийлүүлэх бүтээгдэхүүн/	13-16
3.2. Шалгуур үзүүлэлтүүд	16-17
3.3. Биеийн тамир, спортын хөгжлийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, Үнэлгээ	17
3.4. Хяналтын механизм	17-19
3.5. Төсөвлөсөн санхүүгийн тайлан	19-23
3.6. Өмчлөлийн бусад зорилтууд	24-25
3.7. Нөөцийн ашиглалт, сайжруулалт	25-27
3.8. Эрсдэл учирч болох хүчин зүйлүүд	27-28

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

4.1. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг баталгаажуулах хэрэгжүүлэх арга хэлбэр:	28
--	----

ХАВСРАЛТ:

- Хавсралт №1. Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтууд
- Хавсралт № 2. “Үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ –
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Ш.АНХМАА

2017 он 02 сар 01 өдөр

УДИРТГАЛ

Аливаа байгууллагын оршин тогтнох, хөгжих үндэс нь үндэслэлтэй боловсруулагдсан урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, тэрхүү төлөвлөгөөнүүдээ амжилттай хэрэгжүүлэх механизмыг зөв бүрдүүлэх явдал мөн. Иймд Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хороо нь дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж ажиллахаар төлөвлөж байгаа нь үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлэхэд дөхөм болох юм.

Стратеги төлөвлөгөөг “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж боловсрууллаа.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас баримтлах эдийн засаг, нийгмийн бодлогын томоохон бүрэлдэхүүн хэсэг нь биеийн тамир, спортыг бүхий л талаар хөгжүүлэх явдал бөгөөд Биеийн тамир, спортын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэхүү дунд хугацааны стратеги чиглэгдэнэ.

Энэхүү стратегийн төлөвлөгөө нь нэг талаас Биеийн тамир, спортын тухай хуулийг хэрэгжүүлэх шаардлага боловч хамгийн гол нь биеийн тамир, спортын салбарын удирдлага, төлөвлөлтийг шинэ шатанд гаргахад дорвитой хувь нэмэр оруулах төдийгүй нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагуудын хөгжил дэвшлийг хангах бодлогын чиглэл, үйл ажиллагааны удирдамж болох үүргийг гүйцэтгэх болно.

Төлөвлөгөөг боловсруулах явцад нийслэл дүүргийн БТС-ын байгууллагуудын нийлүүлэх бүтээгдэхүүнийг оновчтой тодорхойлох, тэдгээрт хамаарах гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сонгон боловсруулахад анхаарч шалгуур үзүүлэлтүүдийг Ерөнхий менежерийн болон төрийн албан хаагчийн Үр дүнгийн гэрээнд харилцан уялдаатайгаар тусгахыг эрмэлзсэн болно.

Энэхүү дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад байгууллагын жил бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх боломжуудыг илрүүлэн нэмэлт тодотгол оруулж байх болно.

Энэхүү төлөвлөгөө нь байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний эх үндэс болж өгөхийн зэрэгцээ стратегийн чиг хандлагыг тодорхойлж байгаа учраас ажилтан бүрийн ажлын чиглэл, хөшүүрэг болно.

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах” тухай Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар тогтоолын дагуу “Биеийн тамир, спортын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд эрхлэн зохион байгуулах Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын салбарын бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтийн зохицуулалтыг эрхлэхийн зэрэгцээ түүний тогтвортой үйл ажиллагааг ханган, хүн амын дунд явуулах нийтийн биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцдаг.

Үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ, зорилго нь хүн амын бие бялдар, чийрэгжилтийн өнөөгийн байдал, биеийн тамир, спортын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, шийдвэрлэвэл зохих асуудлууд, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга замыг судлан, тодорхойлоход оршино.

Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, үр дүнд чиглэсэн удирдлагыг амжилттай нэвтрүүлэх, ажилтан нэг бүрийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, нэгдсэн зорилго, үр дүнд чиглүүлэх явдалд энэ төлөвлөгөө бодит үүрэг гүйцэтгэнэ.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны зүгээс Нийслэлийн Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний биелэлтийг хангахад ажлыг чиглүүлэх, төсвийг оновчтой хуваарилахад анхаарахын зэрэгцээ ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх, хариуцлага, санаачлагыг нэмэгдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон ажлуудыг хэрэгжүүлэх болно.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,
спортын хорооны дарга



Ж.Ганболд

2017 оны 02 дугаар сарын 01-ны өдөр

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Дунд хугацааны стратеги төлөвлөгөө
боловсруулсан арга зүй:****1.1. Үндэслэл:**

Монгол Улсын Үндсэн хууль, “Засгийн газрын тухай” хууль, “Яамдын эрх зүйн байдлын тухай” хууль, “Төрийн албаны тухай” хууль, “Хөдөлмөрийн тухай” хууль, “Биеийн тамир, спортын тухай” хууль, Монгол Улсын бусад хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомжууд болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах” тухай Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар тогтоол, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого” батлах тухай Улсын Их Хурлын 2009 оны 95 дугаар тогтоол зэрэг эрх зүйн актуудыг тус төлөвлөгөөг боловсруулах явцад үндэслэл болгон ашигласан болно.

Стратеги төлөвлөгөөг “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр” “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсрууллаа.

1.2. Эрх зүйн орчин:

Энэхүү дунд хугацааны стратеги төлөвлөгөөг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
- Биеийн тамир, спортын тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого” батлах тухай Улсын Их Хурлын 2009 оны 95 дугаар тогтоол,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах” тухай Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар тогтоол,
- Монгол Улсын бусад холбогдох хууль тогтоомжууд.

1.3. Арга зүй:


Байгууллагын түүхэн хөгжил, өнөөгийн төлөв байдалд ерөнхий орчин, бичил орчны шинжилгээ хийсний үндсэн дээр стратеги төлөвлөгөөний алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлсон.

Стратегийн зорилго, зорилт, үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг чиг үүргийн давхардал, хийдэгдэлгүй жигд хуваарилан ногдуулах, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх зарчмыг баримтлан гаргасан болно.

ННБТСХ-ны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг байгууллагын даргын 201.. оны ...дүгээр сарын ...-ны дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, тус байгууллагын ажилтан, албан хаагчдыг оролцуулж, өнөөгийн төлөв байдал, үндэслэл → орчны шинжилгээ → алсын хараа → эрхэм зорилго →

стратегийн зорилтууд → хэрэгжүүлэх арга механизм → хүрэх үр дүн → хяналт, үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу гүйцэтгэлээ.

Схем 1. Стратеги төлөвлөгөөний арга зүйн дараалал



Байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхижуулах, болон бусад байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд үзүүлэх төр, засгийн үйлчилгээг шуурхай болгох бодит шаардлагыг стратеги төлөвлөгөө боловсруулах явцад харгалзан үзэж, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын нөхцөлийг сайжруулах, иргэдэд шударга, шуурхай үйлчлэх шилдэг хамт олныг бүрдүүлэх явдлыг гол стратеги хэмээн үзлээ.

1.4. Орчны шинжилгээ:

Байгууллагын түүхэн хөгжлийн үе шат, өнөөгийн төлөв байдалд дотоод, гадаад орчны хүчин зүйл хэрхэн нөлөөлж байгааг “давуу тал”, “сул тал”, “боломж”, “аюул занал” гэж 4 бүлэг болгон авч үздэг байгууллагын орчны шинжилгээний олон улсын арга, туршлагыг хэрэглэхийн тулд гадаад, дотоод орчныг дараах байдлаар хоёр ангилж тодорхойллоо.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны түншлэлийн хүрээний орчин нь:

- Дотоод орчин буюу Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны болон түүний зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, дүүргийн БТСХороод аж ахуйн нэгж, байгууллага дахь арга зүйчид;
- Гадаад орчин буюу Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороотой байнгын харилцаа, хамтын ажиллагаатай ажилладаг дотоодын болон олон улсын, гадаад орны байгууллагууд юм.

Дээрх шинжилгээг хийхдээ уг аргын үндсэн мөн чанарын дагуу дотоод, гадаад орчноос ННБТСХ-ны стратеги, үйл ажиллагаанд үзүүлж байгаа нөлөөллийг тус бүрт нь тодорхойлсон. Үүнд:

Хүснэгт-1

	Давуу тал	Сул тал
Дотоод орчин	- МУ-ын нутаг дэвсгэрийн хуваарилалт, түүний удирдлагын тухай хууль”, “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн дагуу Нийслэлийн биеийн тамир спортын байгууллагуудын үйл ажиллагааг хуульчилж өгсөн. “Биеийн тамир, спортын тухай” хууль, ЗГ-ын тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болсон. - ННБТСХ-ны үйл ажиллагааны стратеги зорилт, ажлын байрны тодорхойлолт гарсан. - Биеийн тамир, спортын байгууллагын санхүү, хүний нөөцийн чадавхи зохих түвшинд хүрсэн. - Байгууллага төрийн захиргааны байгууллагын шинэ бүтэц, зохион байгуулалтаар ажиллаж байна. - Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд нийслэлийн төрийн болон нутгийн удирдлага, төрийн бус байгууллага иргэдийг татан оролцуулах боломжтой - Өөрийн ажлын байр, зохих хэмжээний тоног төхөөрөмжтэй.	- Биеийн тамир, спортын салбарын урт хугацааны бодлого, стратеги үгүйлэгдэж байна. - Биеийн тамир, спортын салбарт стандартчилал хангалтгүй. - Дүүргийн болон нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагын хүний болон санхүүгийн нөөц хязгаарлагдмал. - Бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж, хөрөнгө мөнгө хязгаарлагдмал. - Салбарын хүний нөөцийн чадавхи сул. - Салбарын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа муу, мэдээлэл солилцоо, ажил үүргийн уялдаа холбоо сул - Байгууллага өөрийн гэсэн байр, заалгүй. -Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан тусгай хөтөлбөр, арга хэмжээ байхгүй. -Ажилтан, албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулах ажил хийгддэггүй. -Хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр байхгүй.

	Боломж	Бэрхшээл
Гадаад орчин	- УИХ-аас “Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг батлан гаргаж биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны эрх зүйн орчин шинэчлэгдсэн. -Мэдээлэл, технологийн орчин үеийн ололтыг салбартаа нэвтрүүлэх замаар үйл ажиллагаагаа олон нийтийн эрх ашигт нийцүүлэх чиглэлээр хөнгөн шуурхай, хүртээмжтэй болгох эхлэл тавигдсан. -Тамирчдын залуу халааг бэлтгэх тогтолцоог бүрдүүлсэн. - Нийслэлийн бүх дүүрэгт Биеийн тамир, спортын хороод үйл ажиллагаа явуулдаг. -Биеийн тамир, спортын салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж, аймаг, нийслэл, дүүрэгт спортын ордон, усан бассейн шинээр баригдаж байна. - Хөрш ОХУ, БНХАУ болон гадаад бусад орны биеийн тамир, спортын байгууллагатай холбоо тогтоон хамтран ажиллах, туршлага судлах боломжтой. -Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд биеийн тамир, спортыг дэмжих хандлага, оролцоо нэмэгдсэн нь Биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөж байна. - Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа нь ННБТСХ-ны ажлын ачаалалыг хуваалцах боломжийг бүрдүүлж байна.	-Хөдөө орон нутгаас хүн амын шилжин ирэх хөдөлгөөнөөс хамааралтайгаар хүн амын төвлөрөл ихэссэн. - Хүн амын амжиргааны түвшин доогуур байна. -Иргэд биеийн тамир, спортоор хичээллэх нийгмийн орчин нөхцөл хангалтгүй, хөрөнгө санхүүгийн хомсдолтой. -Хүн амын эрүүл мэндийг сайжруулахад чиглэгдсэн биеийн тамир, спортын зардал маш бага, орон нутгийн төсөвт биеийн тамир, спортын үйл ажиллагаатай холбогдолтой зардал тусгагддаггүй. -Биеийн тамир, спортыг дэмжих татварын болон бусад хууль, эрх зүйн орчин бүрдээгүй. - Ажилтан албан хаагчдын орон тоо хүрэлцээгүй байгаа нь ажил үүргийн давхардал бий болгож ажлын ачаалалыг нэмэгдүүлж байна. -Биеийн тамир, спортыг дэмжиж, ивээн тэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх татварын болон бусад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн үндсэн чиглэл:**2.1. Алсын хараа:**

Нийслэл хотын хүн амд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж, тамирчдын амжилтын түвшинг дээшлүүлж, **хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж**, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлнэ.

2.2. Эрхэм зорилго:

Биеийн тамир, спортын үйлчилгээг нийслэл хотын айл өрх, иргэн бүрт хүргэж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж, халааг тасралтгүй бэлтгэх орчин, нөхцлийг бүрдүүлнэ.

2.3. Үнэт зүйлс:

- Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц: Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, өөрийгөө болон бусдыгаа байнга хөгжүүлдэг албан хаагчдаа бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Манлайлал: Байгууллагын хөгжлийг олж тодорхойлогч, бусдыг үлгэрлэн дагуулж, урам зоригийг бадрааж, бодит үр дүнд хүрэх чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Мэргэжлийн бүтээлч хандлага: Асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, сайжруулж хөгжүүлэх, шинэ санал, санаачлагыг бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Үнэнч шударга зарчим: Хууль тогтоомжийг дээдлэн эрхэлсэн ажилдаа үнэнч шударга, өөриймсөг хандан сэтгэл гарган ажилладаг хандлагыг бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Хамт олны нэгдмэл байдал: Хамт олны харилцан итгэлцлэл, хүндлэл, нэгдмэл байдлыг бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Иргэд, олон нийтийн итгэл: Байгууллага, аж ахуйн нэгжийн түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг бид үнэт зүйлс гэж үзнэ.
- Байгууллагын туг, бэлэгдэл: Албан хаагчдын хийморь, золбоо, өргөсөн тангарагтаа үнэнч байх итгэл үнэмшил болсон Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спорт хорооны туг, бэлэгдлүүдийг бид үнэт зүйлс гэж үзнэ.

2.4. Эрхэмлэх зарчим:

- Шударга, ил тод, хуулийг дээдлэх: Хууль тогтоомжийг дээдлэн үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод, тэгш байдлыг хангана.
- Мэдлэг чадвартай байх: Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх мэдлэг чадварыг эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлэн төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.
- Мэргэшсэн тогтвортой байх: Хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн томилно.
- Хариуцлага, ёс зүйтэй байх: Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албаны манлайлал, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэж ажиллана.

- Бүтээлч, санаачилгатай байх: Аливаа асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандаж, шинэ техник, технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн албан хаагч бүр хариуцсан ажилдаа бүтээлч, санаачилгатай байна.

- Суралцагч хамт олон байх: Албан хаагчдын сурч хөгжих, ахиж дэвших орчныг бүрдүүлнэ.

- Иргэд, олон нийтэд түшиглэх: Байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлж, өөрийн үйл ажиллагаагаар тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж, харилцан хамтарч ажиллана.

- Хяналт-үр дүнг чухалчлах: Дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлж дүгнэж ажиллана.

2.5. Үйл ажиллагааны хамрах хүрээ:

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь “Биеийн тамир, спортын тухай хууль” болон бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд эрхлэн зохион байгуулах эрхтэй төрийн захиргааны байгууллага мөн.

Иймд Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагаа нь нийслэлийн хүн амыг биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхитэй хөдөлгөөн хийх, спортын өндөр амжилт гаргах боломжийг бүрдүүлэхтэй холбогдох хөтөлбөр, чиглэл, төсөл, журам, заавар гаргах, биелэлтийг хангуулах, зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамарна.

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн зорилго:

Иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлж, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн биеийн тамир, спортын ажил үйлчилгээ, орчин нөхцөлийг сайжруулахад гол зорилго оршино.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь стратеги зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 1. Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах

Стратегийн зорилт 2. Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Стратегийн зорилт 3. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох

Стратегийн зорилт 4. Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох

2.6. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

2.6.1. Стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.1.1. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын спортын цогцолборын барилгыг барьж дуусгах;

2.6.1.2. Олон улсын шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын барилга байгууламжуудыг шинээр барьж байгуулах асуудлыг бодлогоор дэмжиж, нийслэлийн хот төлөвлөлтийн төлөвлөгөө, төсөвт тусган гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

2.6.1.3. Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүхий биеийн тамирын болон тоглоомын талбай, спортын төрөлжсөн заал танхимыг нийслэл, дүүрэг, хороо, хороолол, шинээр байгуулагдах дэд төвүүдэд барьж байгуулах ажлыг нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

2.6.1.4. Биеийн тамир, спортын зориулалттай барилга байгууламжийн судалгааг хийж, ашиглалтыг сайжруулах.

Хүрэх үр дүн:

Орон сууц, хороодод иргэдийн амарч, зугаалах, өдөр тутмын биеийн тамир, чийрэгжүүлэлтийн дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцлийг хангасан талбай, зориулалтын зам тоног төхөөрөмжийн хүртээмж сайжирна.

Сургалтын байгууллага дахь биеийн тамирын боловсрол, бие бялдрын соёл төлөвшүүлэх сургалтын орчин, чанар, дээшилнэ.

Олон улсын шаардлага жишигт нийцсэн орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий спортын төрөлжсөн барилга байгууламжийн тоо нэмэгдэнэ.

2.6.2. Стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.2.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, дүүрэг, хороо, хэсгүүдэд биеийн тамирын хамтлаг байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2.6.2.2. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган аялал, алхалт, гүйлт, иог, фитнесээр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажиллах;

2.6.2.3. Биеийн тамир, спортын ажил үйлчилгээ, барилга байгууламж, зам талбайг барьж байгуулах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачлага, оролцоог дэмжих;

2.6.2.4. Нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах нийтийг хамарсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээнүүдийн тоог нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах;

2.6.2.5. Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, соёлыг дээшлүүлэх, тэднийг биеийн тамирын хичээл, секц дугуйланд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх нөхцөл боломж, заал танхим, хэрэглэл материал, техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.6.2.6. Биеийн тамир, спортын талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн:

Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хандах бүх нийтийн хандлага, дэмжлэг сайжирна.

Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний цар хүрээ чанар дээшилж биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага, иргэд олширно.

2.6.3. Стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.3.1. Нийслэлд үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын залгамж халааг бэлтгэх эрх зүйн болон санхүүгийн таатай орчинг бүрдүүлэх;

2.6.3.2. Багийн спортоор дамжуулан хүүхэд, залуучуудын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх;

2.6.3.3. Нийслэлд олон улс, тив, дэлхийн чанартай биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнийг зохион байгуулахыг дэмжих;

2.6.3.4. Үндэсний спорт, тоглоом наадгайн төрлүүдийг хөгжүүлэх, өсвөрийн хүүхэд багачуудад өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн

Спортын холбоод биеийн тамир, спортын төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа сайжирч, тухайн спортыг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа бодлого чиглэл, үйл ажиллагаа чанаржина.

Өсвөрийн хүүхэд багачуудыг бага наснаас нь спортын авьяасыг хөгжүүлэх, дэмжих, ур чадварыг дээшлүүлэх тогтолцоо сайжирч, спортын төрөлжсөн сургалттай сургууль, гүнзгийрүүлсэн сургалттай анги, түүнд хамрагдах өсвөрийн тамирчдын тоо нэмэгдэнэ.

Үндэсний спорт, тоглоом наадгайг нийслэлийн хүүхэд, залуучуудад өвлүүлэх, хөгжүүлэх ажил сайжирч үндэсний спортын төрлөөр хичээллэгч хүүхэд залуучууд иргэд, тэдний дунд зохион байгуулах үндэсний спортын уралдаан тэмцээн, арга хэмжээний тоо нэмэгдэж, хамрагдах байгууллага, иргэдийн тоо олширно.

2.6.4. Стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.4.1. Биеийн тамир, спортын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, материаллаг бааз, эрх зүй, хөрөнгө санхүүгийн орчинг сайжруулах;

2.6.4.2. Биеийн тамир, спортын сурталчилгаа мэдээлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад, дотоодын байгууллага, иргэдийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх;

2.6.4.3. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг дэмжих, урамшуулах тогтолцоог боловсронгуй болгох;

2.6.4.4. Нийслэлд биеийн тамир, спортын магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжиж хамтран ажиллах.

Хүрэх үр дүн

Нэг хүнд оногдох биеийн тамир, спортын барилга байгууламжийн тоо, зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ.

Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн ажил үйлчилгээтэй холбоотой удирдлага эрх зүйн орчин сайжирна.

Салбарын болон салбар хоорондын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа сайжирч, тэдний оролцоог үнэлэх үнэлэмж урамшууллын тогтолцоо сайжирна.

Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагаа бүтээн байгуулалтын ажилд гадаад, дотоодын байгууллагын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Биеийн тамир, спортын байгууллагуудын магадлан итгэмжлэх тогтолцоо бүрдэж тэдгээр байгууллагуудын бие даасан үйл ажиллагаа сайжирна.

2.7. Хэрэгжүүлэх хугацаа:

Стратеги төлөвлөгөө нь 2017-2020 онд хэрэгжинэ.


2.8. Санхүүжилт:

- а/ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
- б/ Гадаад, дотоодын төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж
- в/ Хандивлагч орон олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив
- г/ Бусад эх үүсвэр

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт:

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь стратегийн эрхэм зорилго, эрхэмлэх зарчмынхаа хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллана.

Схем 2. Байгууллагын бүтэц



3.1. 2017-2020 онд эн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл /нийлүүлэх бүтээгдэхүүн/:

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд дараахи бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр төлөвлөж байна.

3.1.1. Биеийн тамир, спортын хөгжлийн эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар:

-“Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулж НИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх

- Хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

-Байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан нэмэгдсэн орон тоонд шаардлага хангасан тохирох албан тушаалтанг авч ажиллуулах, шаардагдах цалингийн санг төсөвт суулгаж цалинг олгох.

Тоо хэмжээ, хугацаа:

Нийслэлд биеийн тамир, спортыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд 3 бүтээгдэхүүн нийлүүлнэ.

Чанар:

- Биеийн тамир, спортын холбогдолтой гаргах эрх зүйн баримт бичгүүд /тогтоол, шийдвэр, хөтөлбөрийн/-ийн төслийг боловсруулан хэрэгжүүлэхдээ дараахи чанарын шаардлага тавина.

-“Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газар, НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөрийн зорилтуудтай нийцсэн байх,

- Монгол Улсын хөрөнгө, санхүүгийн нөөц, төсөвт нийцэх,

- Албан бичиг баримтын стандартын шаардлага хангах.

Хүн/өдөр:

Жилд 157 хүн/өдрийг зарцуулна.

Өртөг:

-Дээрх ажлыг зохион байгуулахад жилд 26.541.0 мянган төгрөг зарцуулах болно.

3.1.2. Биеийн тамир, спортын хөгжлийн материаллаг орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр:

-Нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортын цогцолборуудыг төрөлжсөн хэлбэрээр барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэх.

-Гэр хороололыг дахин төлөвлөж суурьшлын бүс болгон хөгжүүлэх ажил болон шинэ суурьшил бүс, дэд төвүүдэд хот тосгонд 2004 оны “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-д заасан зохист хэмжээгээр биеийн тамир, спортын барилга байгууламжуудыг тусгаж төлөвлөж хэрэгжүүлэх

-Орон сууц, гэр хорооллын дунд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх гүйлтийн болон дугуйн зам байгуулах.

-Албан газар, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төв, танхим байгуулан ашиглах.

-Нийслэлийн иргэдийг ая тухай аялах нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр явган аялалын зам, маршрутыг дүүрэг бүрт зориулалтын дагуу тогтоож, тохижуулах.

-Нийслэлийн иргэдийг өвлийн улиралд спортоор хичээллэх, аялах орчин нөхцлийг бүрдүүлсэн цогцолборуудын байршлыг тогтоож бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх.

-Биеийн тамир, спортын барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэн засвар хийх, тоног, төхөөрөмж, хэрэглэл материалаар хангахад олон улсын болон монгол улсын стандартыг баримталж хэрэгжүүлэх

Тоо хэмжээ, хугацаа:

Биеийн тамир, спортын хөгжлийн материаллаг орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр 1-3 нэр төрлийн бүтээгдэхүүнийг жил бүр нийлүүлнэ.

Чанар:

-2020 онд Азийн хүүхдийн спортын наадмыг, 2023 онд Зүүн Азийн залуучуудын наадмыг Улаанбаатар хотод зохион байгуулах эрх авсан. 2033 онд болох Дэлхийн оюутны өвлийн спортын “Универсиад-2033” их наадмыг Нийслэлийн Засаг даргын санаачлагаар Улаанбаатар хотноо зохион байгуулах хүсэлтээ илэрхийлж санамж бичигт гарын үсэг зурсан.

Дээрх наадмуудыг зохион байгуулахад шаардлагтай байгаа спортын барилга, байгууламжуудыг тусгаж хэрэгжүүлсэн байна.

-Хүмүүсийн нас, биеийн онцлогт тохирсон орчин үеийн стандартын шаардлага хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

Хүн/өдөр:

Жилд 439 хүн/өдрийг зарцуулна.

Өртөг:

Дээрх ажлыг зохион байгуулахад 27,214,7 мянган төгрөг зарцуулах болно.

3.1.3. Хүн амын дунд зохиох биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний талаар:

-Биеийн тамир, спортыг дэмжих, иргэдэд сурталчилах бүх нийтийн томоохон өдөрлөгүүдийг 5-7 удаа, нийтийг хамарсан явган аялалыг 3-аас дээш удаа жил бүр зохион байгуулна.

-Нийслэлийн төр, захиргааны болон төрийн бус байгууллагууд, Аж ахуй нэгжүүд, Биеийн тамир, спортын байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангах чиглэлээр 7-10 сургалт семинарыг жил бүр тогтмол зохион байгуулна.

-Багийн спортын төрлүүдээр дамжуулан нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүдийн хүүхдүүдийн бие бялдарыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, төлөвшүүлэх зорилгоор сагсан бөмбөг, волейболын “Сурагчдын лиг”, гимнастикийн тэмцээнүүдийг жил бүр 3-4 үе шаттай зохион байгуулна.

-“Биеийн тамир, спортыг айл, өрх, иргэн бүрт” уриан дор Иргэдийн спортын наадмыг жил бүр 7-8 төрлөөр нийслэлийн нийт хүн амын дунд 5 үе шаттай зохион байгуулна.

-Нийслэлийн иргэдийн бие бялдын чийрэгжилтийн түвшинг жил бүр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдээр тогтоож үр дүнг тооцож байна.

-Жил бүр спортын 15-аас доошгүй төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.

-Тив, дэлхий, олон улсын спортын тэмцээнд тамирчдыг бэлтгэх, оролцуулах, өөрийн оронд олон улсын тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

-Дүүрэг бүрт өсвөрийн шигшээ багийг “Биеийн тамир, спортын тухай” хуулийн дагуу 8-аас дээш төрөлд хүргэн байгуулж өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.

-Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагддаг Оюутны спортын их наадам, Үндэсний спортын их наадам, Хүүхдийн спортын их наадам, Бүх ард түмний спортын их наадмуудыг жил бүр ээлжлэн зохион байгуулна.

-“Аз жаргалтай Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд “Улаанбаатар-Марафон” олон улсын гүйлт, Дугуйн марафон, “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадам, Дуулиан-2020” хөл бөмбөгийн тэмцээн зэрэг томоохон үйл ажиллагааг жил бүр 3-аас дээш удаа зохион байгуулна.

Тоо хэмжээ, хугацаа:

- Хүн амын дунд биеийн тамир, спортын үйл ажиллагааг хүргэх чиглэлээр 60-аас дээш нэр төрлийн бүтээгдэхүүнийг жил бүр нийлүүлнэ.

Чанар:

- Төсвийн хөрөнгө, санхүүг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах,
- Хүн амын биеийн тамир, спортоор хичээллэх идэвх санаачлагыг дэмжиж туслах,

- Бага зэрэглэлтэй тамирчдын спортын ур чадварыг дээшлүүлж олон улсын түвшинд хүрч өрсөлдөх хэмжээнд хүргэх,

- Биеийн тамир, спортыг иргэний эрүүл мэндийг хамгаалах өдөр тутмын ажил, үйлчилгээ болгох.

-Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулах.

Хүн/өдөр:

Жилд 1444 хүн/өдрийг зарцуулна.

Өртөг

Дээрх ажлыг зохион байгуулахад жилд 244,113,9 мянган төгрөг зарцуулах болно.

3.2. Шалгуур үзүүлэлтүүд:

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

1. Өдөр тутмын биеийн тамир, спортоор тогтмол хичээллэдэг иргэдийн тоо жил бүр тогтмол 1-2 хувиар нэмэгдэж, 2020 онд нийслэлийн хүн амын 25 хувь ба түүнээс дээш хувьд хүрсэн байна.

2. Нийслэлийн дүүрэг бүр өөрийн биеийн тамир, спортын заалтай, усан бассейнтай болно.

3. Нийслэл Улаанбаатар хотод олон улсын шаардлагад нийцсэн өвөл зуны төрөлжсөн спортын заал танхим, цогцолборын тоо нэмэгдэж олон улс, тив, дэлхийн чанартай томоохон уралдаан тэмцээнийг зохион байгуулах нөхцөл

бололцоо сайжирснаар түүнд гадаад орнуудаас ирж оролцох баг тамирчид, төлөөлөгчдийн тоо нэмэгдэнэ.

3.3. Биеийн тамир, спортын хөгжлийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- Биеийн тамир, спортын үйл ажиллагааг төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах,

- Биеийн тамир, спортын мэдээллийг байгууллагын вэб сайтад байршуулан нийтэд мэдээлэх,

- Биеийн тамир, спортын салбарын бодлого, хөтөлбөр, зорилтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тэдгээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг дээшлүүлэх, илэрсэн дутагдлыг арилгахаар чиглэсэн удирдлагын шийдвэр гаргахад дотоод дэмжлэг үзүүлэх.

- Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ыг баримтлана.

Тоо хэмжээ, хугацаа:

- Жилд хоёроос доошгүй бодлого, зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, улирал тутам мэдээллийн сангийн баяжилтыг вэб сайтад байршуулна.

Чанар:

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь дараах чанарын шаардлагыг хангана.

- Батлагдсан журам, аргачлалын дагуу хийгдэх
- Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь үнэн зөв байх
- Санал, зөвлөмж нь цаг үеэ олсон байх.

3.4. Хяналтын механизм:

Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, нөлөөг дээшлүүлэх, Нийслэлийн Засаг даргад нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарын болон хугацааны шаардлагыг хангахын тулд санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн шийдвэр гаргах үйл явцад тавих гэрээний хариуцлагыг чанд мөрдөж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтын механизмуудыг ашиглана.

3.4.1. Санхүүгийн хяналт:

ННБТСХ-ны жилийн батлагдсан төсвий зарцуулалт, үр дүнгийн байдалд тавих хяналтыг Ерөнхий менежер буюу ННБТСХ-ны дарга зохион байгуулна.

ННБТСХ-ны төсвийн санхүүжилт нь байгууллагын үйл ажиллагааны чиглэл бүрээр хуваарилагдах бөгөөд төсвийн санхүүжилтийн байдлыг нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээтэй холбон авч үзнэ. Төсвийн зарцуулалтын тайланг сар, улирал, жилээр гаргаж байгууллагын даргад мэдээлэн холбогдох байгууллагуудад тайлагнана.

Төсвийн хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, өр авлагагүй байгууллага байх зэрэг арга хэмжээг авна.

3.4.2. Үйл ажиллагааны хяналт:

Үйл ажиллагааны түвшинд тавих хяналтыг үр дүнгийн гэрээний биелэлтийг хангахад чиглүүлнэ. Энэ нь хариуцлага, тайлагналын харилцаанд нэвтрүүлсэн оновчтой менежментийн арга барил юм.

Ерөнхий менежер нь нэгжийн мэргэжилтэн нэг бүртэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах бөгөөд гэрээний үндсэн хэсэг нь энэхүү төлөвлөгөөнд тодорхойлогдсон төсвийн жилд нийлүүлэх бүтээгдэхүүн байна. Өөрөөр хэлбэл, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт нь төсвийн ерөнхийлөн захирагчийн, ерөнхий менежерийн, хэлтсийн дарга нарын гэсэн түвшинтэй байна.

Ерөнхий менежерээс мэргэжилтнүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэнэ. Нийслэлийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнэнэ. Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон хууль тогтоомж, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг улирал, жилээр дүгнэж, тайлан мэдээг нэгтгэн гаргаж, хэрэгжээгүй буюу хагас биелэлттэй ажлын талаар байгууллагын удирдлага, мэргэжилтэн нарт мэдээлж, эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3.4.3. Удирдлагын зүгээс шийдвэр гаргах үйл явцад тавих хяналт:

ННБТСХ-ны даргаас шийдвэр, тушаал гаргахад мэргэжилтнүүдээс ажлын байрны чиг үүргийн дагуу төслийг бэлтгэж, уг шийдвэрийн үндэслэлийг боловсронгуй болгох, хууль тогтоомжид нийцүүлэхэд нь зөвлөгөө өгч, дэмжлэг тусалцаа үзүүлнэ. Хөрөнгө зарцуулах, төрийн албан хаагчийн асуудлыг шийдэх тушаалын төслийг дээр дурьдсан журмаар бэлтгэж, холбогдох мэргэжилтэн, гарын үсэг зурж, шийдвэрийн ил тод байдлыг хангана.

Байгууллагын дарга биеийн тамир, спортын асуудлаар гаргах зарим шийдвэр, дээд байгууллагад оруулах асуудлыг нийслэл, дүүргийн БТС-ын байгууллагуудын хэмжээнд урьдчилан хэлэлцэж, гарсан дүгнэлт, саналыг тусгана.

Мөн зарим асуудлаар салбарын нарийн мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн, судлаачид, байгууллага, иргэдийн санал авах, ажлын хэсэг байгуулан ажиллуулах замаар шийдвэр гаргах үйл явц ард олон нийтийн оролцоог өргөтгөж дэмжлэг үзүүлнэ.

3.4.4. Шийдвэрийн биелэлтэд тавих хяналт:

Биеийн тамир, спортын талаар УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, НИТХ, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, хугацаатай өгсөн үүргийг нэг бүрчилэн бүртгэж, хяналтад авч, түүний биелэлтийг холбогдох газар, байгууллагад зохион байгуулж, сурталчилж, үр дүнг улирал бүр дүгнэн, биелэлтийн тайлан мэдээг холбогдох дээд байгууллагад улирал, хагас, бүтэн жилээр мэдээлж байна.

Мөн дээд байгууллагаас болон байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг байгууллагын ажилтнууд болон харъяа газар, байгууллагад шалгаж дүгнэх ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч эргэх холбоотой ажиллана.

Даргын тушаалаар хугацаатай өгөдсөн үүргийг хяналтад авч, биелэлтийг сар, улирлаар гарган дүгнэж, тасарсан болон хугацаа хэтэрч буй асуудлуудыг холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж, биелэлтийг хангах арга хэмжээ авна.

3.5. Төсөвлөсөн санхүүгийн тайлан

3.5.1. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл:

Ерөнхий менежер Ж.Ганболд, ерөнхий нягтлан бодогч О.Эрдэнэцэцэг нар байгууллагын 2017-2020 онуудын төсөвлөсөн санхүүгийн тайланд тусгасан үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг үнэн зөв тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Төсөвлөсөн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв байх
2. Байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан байх
3. Төсөвлөсөн санхүүгийн тайлан нь иж бүрэн байх

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,
спортын хорооны дарга

Ж.Ганболд

Ерөнхий ня-бо

О.Эрдэнэцэцэг

2017 оны дугаар сарын ...-ны өдөр

3.5.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба төсвийн таамаглалын талаархи мэдэгдэл:

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь 2017-2020 оны төсвийн хүрээний мэдэгдлийг ННБТСХ-ны үйл ажиллагааны урсгал зардал, төвлөрсөн арга хэмжээний зардлыг он оноор тооцоолон, зарлагын зүйл, ангид хуваарилан гаргав.

ННБТСХ-ны 2016 оны төсвийн зарлагын тайлан,
2017-2020 оны төсөвлөсөн санхүүгийн төсөл

/мян.төгрөг/

Үзүүлэлт	2016 оны гүйцэтгэл	2017 он		Төсвийн төслийн санал, таамаглал		
		Батлагдсан төсөв	Хүлээгдэж буй гүйцэтгэл	2018 оны төсөл	2019 он төсөөлөл	2020 он төсөөлөл
Хөтөлбөр /Жишээ: Орон нутгийн засаг захиргаа/						
Зориулалт /Жишээ: Үндсэн үйл ажиллагаа/						
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378 965,3	407 860,7	407 860,7	668 241,3	2718 130,0	2 959 010,0
УРСГАЛ ЗАРДАЛ	378 965,3	407 860,7	407 860,7	668 241,3	2 718 130,0	2 959 010,0

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376 965,3	406 860,7	406 860,7	668 241,3	2 718 130,0	2 959 010,0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	107 484,5	98 608,1	98 608,1	282 385,3	2 126 000,0	2 334 000,0
Үндсэн цалин	99 884,5	91 339,9	91 339,9	121 766,8	1 450 000,0	1 600 000,0
Нэмэгдэл	-			47 512,0	180 000,0	198 000,0
Унаа хоолны Хөнгөлөлт	7 600,0	7 274,2	7 274,2	20 812,0	188 000,0	212 000,0
Урамшуулал				20 294,5	228 000,0	244 000,0
Гэрээт ажлын цалин				72 000,0	80 000,0	80 000,0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11 817,9	10 846,9	10 846,9	31 062,4	233 860,0	256 740,0
Тэтгэврийн даатгал	7 517,7					
Тэтгэмжийн даатгал	537,4					
ҮОМШ-ний даатгал	1 074,8					
Ажилгүйдлийн даатгал	537,4					
Эрүүл мэндийн даатгал	2 150,6					
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13 167,8	11 999,5	11 999,5	12 000,0	12 000,0	12 000,0
Гэрэл, цахилгаан	3 446,6	-	-			
Түлш, халаалт	-	-	-			
Цэвэр, бохир ус	-	-	-			
Байрны түрээс	9 721,2	11 999,5	11 999,5	12 000,0	12 000,0	12 000,0
Хангамж, бараа материалын зардал	9 168,3	9 107,1	9 107,1	14 200,0	14 600,0	14 600,0
Бичиг хэрэг	1 348,0	1 811,6	1 811,6	2 400,0	2 600,0	2 600,0
Тээвэр шатахуун	6 192,6	6 200,0	6 200,0	7 000,0	7 000,0	7 000,0

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 627,7	1 095,5	1 095,5	4 800,0	5 000,0	5 000,0
Эд хогшил, урсгал засварын зардал	4 000,0	-	-	7 000,0	7 000,0	7 000,0
Тавилга	2 000,0	-	-	3 000,0	3 000,0	3 000,0
Урсгал засвар	2 000,0	3 991,8	3 991,8	4 000,0	4 000,0	4 000,0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 124,4	34 042,9	34 042,9	34 670,0	34 670,0	34 670,0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2 418,5	30 000,0	30 000,0	30 000,0	30 000,0	30 000,0
Мэдээллийн технологийн үйлчилгээ	1 352,3	3 215,6	3 215,6	3 840,0	3 840,0	3 840,0
Газрын төлбөр	353,6	827,3	827,3	830,0	830,0	830,0
Бараа үйлчилгээний бусад зардал	434 522,2	242 256,2	242 256,2	286 923,6	290 000,0	300 000,0
Бараа үйлчилгээний бусад зардал						
Биеийн тамирын уралдаан тэмцээн	434 522,2	242 256,2	242 256,2	286 923,6	290 000,0	300 000,0
ТАТААС						
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ						
Бусад урсгал шилжүүлэг	2 000,0	1 000,0	1 000,0	3 000,0	3 000,0	3 000,0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-			
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 000,0	1 000,0	1 000,0	3 000,0	3 000,0	3 000,0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ	378 965,3	407 860,7	407 860,7	-	-	

ЭХ ҮҮСВЭР						-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 601595,8	407 860,7	407 860,7			
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих						
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ						
БАЙГУУЛЛАГЫН ТОО						
Төсвийн байгууллага	1	1	1	1	1	1
АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	16	16	16	16
Удирдах ажилтан	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх ажилтан	7	15	15	15	15	15
Үйлчлэх ажилтан	-					
Гэрээт ажилтан						
АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	16	16	16	16
Төрийн захиргаа	7	14	14	14	14	14
Төрийн тусгай	-					
Төрийн үйлчилгээ	1	2	2	2	2	2
АА						

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,
спортын хорооны дарга

Ерөнхий ня-бо

Ж.Ганболд

О.Эрдэнэцэцэг



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨВЛӨСӨН ТАЙЛАН

/мян.төгрөг/

Үзүүлэлт	2016 оны төсөв	Төсөв, хөрөнгийн таамаглал			
		2017	2018	2019	2020
Эхний үлдэгдэл	60909.6	65509.6	65509.6	108973,3	108973,3
Тайлангийн хугацаанд нэмэгдэх өмч хөрөнгө	4600.0	0	43463.7	0	0
Хасагдах өмч хөрөнгө	0	0	0	0	0
Эцсийн үлдэгдэл	65509.6	65509.6	108973,3	108973,3	108973,3

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,
спортын хорооны дарга

Ерөнхий ня-бо



Ж.Ганболд

О.Эрдэнэцэцэг

3.5.3. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд:

Төсөвлөсөн хөрөнгө, санхүүгийн нэмэлт тодотголууд ННБТСХ-ны 2017-2020 оны төсвийн төслийг хийхдээ дараахь нэмэлт тооцоо, судалгааг гаргасан болно.

- Бүтээгдэхүүний өөрийн өртөг тооцох хүн өдөр
- Өмч хөрөнгийн судалгаа, хөрөнгө оруулалтын төсөв
- Өр, авлагын тооцоо, гэрээ, түрээсийн зардал
- Хүний нөөцийн бүртгэл, цалин, НДШ-ийн тооцоо, нэмэгдэл хөлс, шагнал урамшлын тооцоо.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир,
спортын хорооны дарга

Ерөнхий ня-бо



Ж.Ганболд

О.Эрдэнэцэцэг

3.6. Өмчлөлийн бусад зорилтууд

3.6.1. Өмчлөлийн зорилт:

Өмчлөлийн бусад зорилтууд нь хэтийн төлөвлөгөөний стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхтэй уялдуулан Ерөнхий менежерээс Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны хэмжээнд ашиглагдаж байгаа хөрөнгө, нөөцийг зохицуулан өөрчлөх, сайжруулах, эд хөрөнгө худалдан авах, актлах, худалдах, хөрөнгө оруулалт хийх, ажилтнуудаа сургах, урамшуулах, арга барилын өөрчлөлт хийх зэрэг өмчлөгчийн эрхийг хууль, эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд энэ нь эцсийн дүнд хөрөнгийн ашиглалт, нөөц боломжийн үр дүнг сайжруулан эрсдлийг аль болох багасгахад чиглэгдэнэ.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь үйл ажиллагааны цар хүрээ, зохион байгуулалтын шинэ зарчимд шилжиж байгаатай холбогдуулан төрийн захиргааны төв байгууллагаас үзүүлэх үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс 2017-2020 онд өмчлөлийн талаар дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Өмчлөлийн зорилт 1.

Төрийн албан хаагчдын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор тэдгээрийн мэдлэг, чадвар, чадавхийг сайжруулна.

Энэхүү зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Шинээр томилогдсон албан хаагчдыг ажлын байрны чиг үүргийн дагуу сургалт-семинарт хамруулан мэргэшүүлнэ.

- Төрийн захиргааны албан хаагчдыг ажил, мэргэжлийн холбоотой тодорхой чиглэлүүдээр гадаад, дотоодод урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

Өмчлөлийн зорилт 2.

Байгууллагынхаа ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулах эрх зүйн баталгааг нь бэхжүүлэх, урамшуулал, хариуцлагын зохистой механизмыг хэрэгжүүлнэ.

Энэхүү зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажилтнуудын жилийн Үр дүнгийн гэрээний үр дүнгээр урамшуулдаг тогтолцоог нэвтрүүлнэ.

- Мэдээллийн гадаад, дотоод сүлжээнд холбогдох компьютер, техник хэрэгслийн хангамжийг сайжруулна.

- Тамирчид, дасгалжуулагчдын урамшууллын журмыг шинэчлэн батлуулж мөрдөж ажиллана.

Өмчлөлийн зорилт 3.

Байгууллагынхаа ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулж ажлын байрны чиг үүргийг оновчтой болгоно. Энэхүү зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Мэргэжилтнүүдийн ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдэгдэл, ачааллыг судалж, зарим Ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж мөрдүүлнэ.

- Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнтэй уялдсан урамшуулал, хариуцлагын тогтолцоог бий болгох, мэргэжлийн чадварлаг боловсон хүчний нөөцөө хадгалахад чиглэсэн боловсон хүчний бодлого, менежментийг уян хатан, ил тод болгоно.

3.6.2. Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад зорилт:

№	Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа /сараар/	Хүрэх үр дүн
1	2017 оны төсвийг үр ашигтай зарцуулах	- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу оновчтой хуваарилна. - Төсвийг өөр зориулалтаар болон хэтрүүлэн хэрэглэхгүй байна. - Санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргана.	I-XII	Төсвийг хэтрүүлэхгүйгээр үр дүнгийн гэрээнд заагдсан бүтээгдэхүүнийг шаардлага хангасан түвшинд нийлүүлнэ.
2	Байгууллагын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх	- Байгууллагын сул орон тоог зохих журмын дагуу нийтэд зарлуулан, ТА-ны шалгалтаар тэнцсэн хүнийг авч ажиллуулах - Байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэнэ. - Төрийн захиргааны албан хаагчдыг дотоод, гадаадын сургалт семинарт оролцуулна. - Зарим мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх болон магистрантурын сургалтад хамруулна. - Төрийн захиргааны албанд мэргэшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.	I-XII	Төрийн албаны шаардлага, ажлын байранд тавигдах шаардлагыг ханган ажиллах чадвартай ажилтныг сонгон шалгаруулалтаар авч ажиллуулна. Ажилтнуудын мэдлэг, ажил гүйцэтгэх үр чадвар дээшилнэ.
3	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад ахиц гаргах	- Төрийн албан хаагчдын гадаад хэл, компьютер, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. - Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хэрэгжүүлнэ.	I-XII II-XII	- Төрийн албан хаагчдын гадаад хэл, мэдээллийн технологи, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. -Ажиллах нөхцөл сайжирна.

3.7. Нөөцийн ашиглалт, сайжруулалт:

ННБТСХ нь үйл ажиллагааныхаа тасралтгүй, тогтвортой байдлыг хангахын тулд одоо байгаа ажиллах хүчний, санхүүгийн болон материаллаг нөөцийн ашиглалт, үр нөлөөг дээшлүүлэх, шинээр шаардагдаж буй нөөцийг хуримтлуулах асуудлыг дор дурьдсан байдлаар шийдвэрлэхээр төлөвлөж байна. Үүнд:

3.7.1. Хүний нөөц:

Тус газар нь 2018 оноос нийт 16 хүний батлагдсан орон тоогоороо ажиллах ба үүнээс удирдах албан тушаалтан 3 /ННБТСХ-ны дарга, Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга 1, Спортын хөгжлийн хэлтсийн дарга 1/, мэргэжилтэн 13 хүн ажиллана.

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны ажилтан,
албан хаагчдын орон тооны дээд хязгаар

№	Албан тушаал	Орон тоо
1.	Дарга	1
	Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга	1
	Спортын хөгжлийн хэлтсийн дарга	1
3.	Мэргэжилтэн	13
	Дүн	16

3.7.2. Хүний нөөцийн бодлого:

А.Ажилтан сонгон шалгаруулах талаар

ННБТСХнь ажилтан сонгон шалгаруулж авахдаа шударга, нээлттэй, ил тод, тэгш хандах, өрсөлдүүлэн шалгаруулах зарчмуудыг баримтлах бөгөөд УИХ-аас баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах тухай”, мөн “Төрийн албаны мэргэшлийн шалгалт авах болзол” зэрэг дүрэм журмыг мөрдөнө.

Б. Хүний нөөцийг чадваржуулах талаар

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь төрийн захиргааны албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх нийгмийн хамгааллын баталгааг хангахад чиглэсэн дор дурьдсан арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

- Төрийн захиргааны албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх чиглэлээр сургалтанд хамруулах,

- Салбарын чиглэлээр албан хаагчдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх талаар урт, дунд, богино хугацааны гадаад, дотоодын сургалтанд хамруулах

Ажлын байранд нь сургаж, дадлагажуулах ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу дараах хэлбэрээ зохион байгуулна:

- ✓ Мэдээллийн технологи, албан хэрэг хөтлөлт, компьютерийн зарим шаардлагатай программын сургалтыг дотоод сүлжээ ашиглан зохион байгуулах,
- ✓ Ажил хэргийн ур чадварыг дээшлүүлэх,
- ✓ Тодорхой асуудлаар үүрэг, даалгавар өгөх,
- ✓ Ажлын байрны чиг үүргийн дагуу мэргэшүүлэх сургалт-семинарт хамруулах,
- ✓ Багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, хэвшүүлэх.

Албан хаагчдыг 2017-2020 онд төрийн захиргааны болон салбарын чиглэлээр мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх чиглэл:

- Удирдлага, манлайллын менежмент
- Биеийн тамир, спортын удирдлага, эдийн засгийн төлөвлөлт
- Хүний нөөцийн удирдлага
- Мэдээллийн технологи
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Эрх зүйн сургалт
- Хэлний сургалт

3.7.3. Биет хөрөнгийн нөөц:

Одоо ашиглагдаж буй хөрөнгөтэй холбоотой бусдад төлөх өр төлбөр байхгүй бөгөөд 2018, онд зарим нэг техник, тоног төхөөрөмж, тавилга авахаар төлөвлөж байна. Одоогийн ашиглаж буй биет хөрөнгө нь тухайн төлөвлөгөөний хугацаанд жил бүрийн нийлүүлэх бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд орчин үеийн шаардлага хангасан биет хөрөнгө буюу тоног төхөөрөмж нэмж авах шаардлагатай болно.

Үүнд:

1. Компьютер 10 ком	25.970.000 төг
2. Оффисын ширээ 8 ширхэг	4.200.000 төг
3. Принтер 3 ширхэг	1.253.700 төг
4. Оффисын түшлэгтэй сандал 16	8.400 .000 төг
5. Баримт гар шээш, хувцасны шүүгээ 8 ширхэг	3.640.000 төг

Нийт дүн: 43.463.700 төг

Өнгөрсөн жилүүдэд үнэ ханшийн хэт хэлбэлзэл гараагүй тул үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийхээр төлөвлөөгүй.

Бүтээгдэхүүний бүрэн өртгийг тооцох үүднээс үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохоор төлөвлөж байсан боловч тэдгээр хөрөнгийн ашиглалтын хугацаа ба ашиглалтад орсон жилийг тогтоох боломж олдоогүй тул 2016 оны санхүүгийн жилийн хувьд элэгдлийн зардлыг тооцоогүй болно.

Цаашид бүх хөрөнгөнд, ашиглалтын жилийг тогтоосны үндсэн дээр элэгдэл тооцож, ННБТСХ-оос нийлүүлж буй бүтээгдэхүүний өртөгт шингээх болно.

3.7.4 санхүүгийн нөөц:

ННБТСХ-ноос нийлүүлэх бүтээгдэхүүнд шаардагдах санхүүгийн нөөц нь улсын төсөв, орон нутгийн төсөв өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэх юм. 2017 оны бүтээгдэхүүний өртгийг ННБТСХ-ны зардлаар тооцсон. 2016 оны гүйцэтгэлээр дансны өр ба хуримтлагдсан зардал болон бусад төлөх өр байхгүй байна.

3.8. Эрсдэл:

Өмчлөгч байгууллагад учирч болох эрсдэлд /санхүүгийн болоод бусад эерэг ба сөрөг/ мөн нэгэн адил анхааралтай хандах ёстой. Эрсдэл хэд хэдэн замаар өөрөө өөрийгөө тодорхойлж байдаг. Өмчлөлийн зорилтыг тодорхойлох үүднээс эрсдэлийг дараахь категоруудад бүлэглэж болно. Үүнд:

3.8.1. Болзошгүй өр төлбөр

Төсөвлөсөн санхүүгийн тайланг бэлтгэн танилцуулж байгаа энэ үед ННБТСХ-нд ирээдүйд төлбөр хийх хариуцлагыг бий болгох ямар нэг материаллаг нөлөө бүхий болзошгүй үйл явдал байхгүй байна.

3.8.2. Хууль эрхийн актын үйлчлэлтэй холбоотой эрсдэл

Хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд “Биеийн тамир, спортын тухай” хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, тогтоол, шийдвэрүүд хүлээгдэж байгаа тул ямар нэг эрсдэл гаргахгүй гэх баталгаагүй.

3.8.3. Өмчлөлийн өөрчлөлт

ННБТСХ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар спортын цогцолбор баригдаж байгаа тул өмчлөлийн хувьд 2019-2020 онд өөрчлөлт орно.

3.8.4. Бодлогын өөрчлөлт

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Иймд газрын 2017-2020 оны үйл ажиллагаатай холбогдсон бодлогын шинжтэй өөрчлөлт гарахгүй.

Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг биелүүлэхэд тус газрын ажиллах хүчин, санхүүгийн болон материаллаг нөөц, төсөв хүрэлцэхгүй байх эрсдэл гарч болох юм.

3.8.5. Хөрөнгийн алдагдал

Үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгөнд ямар нэг даатгал хийлгээгүй. Үүнээс учирч болох хөрөнгийн алдагдал төсөвт тусгагдаагүй.

3.8.6. Гадаад валютын ханшны өөрчлөлтийн эрсдэл

Татвар ногдуулалт, төлбөрийг үндэсний валют болох төгрөгөөр гүйцэтгэж байгаа тул гадаад валютын ханшийн өөрчлөлтийн холбоотой эрсдэл гарахгүй гэж төлөвлөсөн.

Гадаадаас биеийн тамир, спортын зориулалтын техник хэрэгсэл худалдан авах, гадаад албан томилолтын зардал зэрэг гадаадын валютаар тооцогдох төлбөр, тооцооны хувьд ханшны өөрчлөлтийн эрсдэл бага зэрэг гарах магадлалтай юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөг баталгаажуулах хэрэгжүүлэх арга хэлбэр:

4.1. Ерөнхий менежерээс Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэх тусгай захиалгат, түүнээс бусад ажил үйлчилгээ, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, манлайлах үр чадвар, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтыг Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусган жил бүр боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлнэ.

4.2. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

4.3. Байгууллагын жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөөг албан хаагчдын жилийн төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаа бүрийг тодорхой ажил үйлчилгээнд задлан төлөвлөж, биелэлтийг тухай бүр гаргаж байна

4.4. Хэрэгжилтийн явц, үр дүнг Ерөнхий менежер, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний хагас, бүтэн жилийн биелэлтийн тайланд тулгуурлан гаргаж, хурлаар хэлэлцэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулна.